

ШИНЖЛЭХ УХААН, СОЁЛ

**ТОД ҮСЭГ БА
НАМХАЙЖАМЦЫН ОРЧУУЛГА**

(Тод үсэг зохиогдсоны 340 жилийн ойд)

Х. ЛУВСАНБАЛДАН

Хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн

Тод үсэг зохиогдоод 340 жил болж байна. Энэ үсгийг Ойрадын эрдэмтэн лам Зая бандид буюу Намхайжамц (1599-1661) гэдэг хүн зохиосон ажээ. Намхайжамцын намтрыг, түүний шавь Раднабадра гэгч зохиожээ. Энэ номыг «Сарны гэрэл» гэдэг. Намхайжамцын намтар УННС-нд хуучин монгол үсгээр, Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөгт тод үсгээр хадгалагдаж байгаа юм. Бас Зөвлөлт Холбоот Улсын Шинжлэх ухааны Академийн Дорнодахины хүрээлэнгийн Ленинградын салбарт тод үсгээр бичсэн бичмэл хэд хэдэн хувилбар бий.

Раднабадраагийн зохиол болон цагийг алгасалгүй дараалах ёсыг чанд баримтлан, тэр үеийн Дөрвөн Ойрадын дотор болсон сайн муу үйл явдлыг нууж хаалгүй бичсэн түүхэн зохиол юм. Энэ намтар найман бүлэгтэй. Үүнд:

1. Зая бандид сахил хүртэж Төвдөд очиж суусан;
2. Төвдөд сууж эрдмийн мухарт хүрч нэр авч лам болсон;
3. Гурван богдын эш зарлигаар Монгол Ойрадоод гарсан;
4. Монгол Ойрадын лам болж ном орчуулан, долоон хошуу Халх, Дөрвөн Ойрадоод шашин дэлгэрүүлсэн,
5. Төвдөд дахин очиж өргөл барьц, эд агуурсыг ихэд өргөсөн;
6. Төвдөөс Ойрадоод буцан ирээд сайн хувьтанд ном үзүүлсэн;
7. Дахин Төвд уруу явах замдаа нас барсан;
8. Зая бандидын хойд дүр хувилан төрсөн ийм найман бүлэгтэй юм.

Ойрадын эрдэмтэн лам Зая бандид буюу Намхайжамцаас монголын соёлын түүхэнд оруулсан хувь нэмэр их юм.

Үүний нэг нь монгол бичгийг засварлан тод болгож тодорхой үсгийг зохиосон билээ. Нөгөө нь 170 гаруй номыг төвд хэлнээс монгол хэлнээ орчуулсан явдал билээ.

I

Он удаан жил нүүдэлчин Монголчуудын алба, амины хэрэгцээнд хэрэглэгдэж ирсэн монгол бичиг XVII зууны үе гэхэд монголчуудын ярианы хэлнээс ихэд зөрөөтэй болсон учраас, тэр бичгийг ярианы хэлэнд ойртуулах оролдлогыг Намхайжамц хийсэн нь бидний хэлэлцэж буй тод үсэг болно.

Нөгөө нэг зорилго нь энэ бичгээр шашны ном орчуулж, Дөрвөн Ойрад, Халх даяарт шарын шашин дэлгэрүүлэх зэвсэг болгон ашиглах ёстой байсан билээ. Ингээд Намхайжамц тод буюу тодорхой үсгээ нийт монголд зориулан зохиосон ажээ. Энэ зорилгоо өөрийн зохиол «Үзгийн найрлага» гэдэг номдоо тодорхойлон бичсэн нь:

«Олон Монгол Улсын хувьтанд хялбар болгохын тулд олон адил дүрстэй үсэгнүүдийг онц тус бүр ангид холицолгүй гийгүүлэн ялгаж олхуяа хялбар монгол үсэг зас гэж дурдсанд (Бавгасбаатарын хүү Очирт тайж, Авлай баатар нар дурдсан)

Хамгийн мэдээч Шагжамуни, Зунхават шашинд тус болохуйн хийгээд

Хатан зүрхтэй харилгүй сүсэгтэнд тус болохуйн тул

Хайрт зарлигийн товч «Үзгийн найрлага» үүнийг

Хамсан зөвлөж Равжамба Зая бандид найруулав» гэжээ. Бэлэxnээ ийм тодорхой баримт байсаар байтал зарим эрдэмтэд тод үсгийг зөвхөн Дөрвөн Ойрадод зориулан зохиосон гэж үздэг. Тод үсгийг зөвхөн Дөрвөн Ойрадод зориулан зохиосон гэж үзэгчид нь тод үсгийн эцсийн хувь заяагаар дүгнэж байгаа явдал биш үү. Тавьсан зорилго, эцсийн үр дүн хоёр заавал адил байх ёстой биш байх аа. Тэр тусмаа Зая бандид мэтийн сүжигтэй лам хүн Далай лам, Банчин-богд нараас монгол, ойрад нутагт шашин дэлгэрүүлэх эш зарлиг аваад зөвхөн ойрад нутгийг салган авч шашин дэлгэрүүлэх зорилго тавьсан байх нь учир шалтгааны ухааны үүднээс тохирохгүй байна. Зая бандид хуучин монгол бичгийн долоон эгшгийн дотор е, о, и, о, и үсгийн дүрсийг ялган тогтоожээ. Үүнээс гадна урт эгшгийг давхарлаж бичих, тухайн эгшгийн ард нь (+) зураас хийх хоёр аргаар ялган тогтоожээ. Энэхүү урт эгшгийн талаар эрдэмтдийн зөрөөтэй санал одоо болтол нэгэн мөр болоогүй байсаар байна.

Зая бандид хуучин монгол бичгийн гийгүүлэгчийн ижил дүрстэй байсан ха, га-гийн төрлийн үсэг, дэ, тэ-гийн төрлийн үсэг, за ца-гийн төрлийн үсгийг ялгаж, ва-гийн төрлийн үсгийг хуучин монгол үсгийн дэ-гийн төрлийн үсгээр орлуулан тогтоожээ. Зая бандид Энэтхэгийн 50 үсэг, төвдийн 30 үсгийг галиглан буулгахад зориулж галиг үсгийг зохиожээ. Энэхүү галиг үсэгтэй холбогдох зохиол гэвэл «олон номын үндсэн үсгийн ялгал», «Тарни унших арга хураасан» гэдэг зохиолуудыг орчуулжээ.

Монголчуудын хэрэглэхээр оролдож байсан үсгүүдийн дотроос хамгийн удаан хэрэглэсэн (одоо ч зарим газар хэрэглэж байгаа) хамгийн их газар дэлгэрсэн үсэг гэвэл тод үсгийг нэрлэж болох юм.

Тод үсгийг Ижил мөрний Халимаг, Баруун монголын Дөрвөд, Баяд, Мянгад, Захчин, Өөлд, Урианхай, Хошууд, Торгууд, БНХАУ-ын Иль, Тарвагатай, Ховог Сайр, Бор тал, Баянгол зэрэг газарт нутаглан сууж буй хошууд, Торгууд, Өөлд, Цахар, Алшаа, Эзнэ голын газраа нутаглаж буй Торгуудад хэрэглэж байсныг үзэхэд тод үсгийн дэлгэрсэн газар нутаг тийм ч бага газар биш билээ.

Үүнээс гадна Чуе голын орчмоор нутаглан суугч түрэг хэлтэн Телингидүүд тод үсэг хэрэглэж байжээ.

Тод үсгийн бичиг баримтыг судлан үзэхэд тод үсгийн дурсгалыг үелэн хуваахгүй бол нэг зүйлийг үзээд түүгээр нийт тод үсгийн баримтыг төлөөлүүлэн дүгнэж хэрхэвч болохгүй. Тод үсгийн дурсгалыг хоёр үед хувааж болно.

Нэгдүгээр үе нь. 1648 оноос XVIII зууны 2-р хагас хүртэл. Энэ үед Зая бандидын зохиосон тод үсгийн дүрэм хэвээр байсан бөгөөд тэр үед холбогдох тод үсгийн дурсгалд Ойрадын аялгууны онцлог гэж дурдах зүйл байхгүй байна.

XVIII зууны хоёрдугаар хагасаас 1924 он хүртэл Халимагт тод үсгийг хэрэглэсэн бөгөөд энэ завсар үсэг зүй, авиа зүй, үг зүй, үгсийн сангийн

талаар Халимагийн аялгууг бүрэн тусгасан Халимагийн тод үсэг болон хувирчээ.

Хоёрдугаар үе нь. XVIII зууны хоёрдугаар хагасаас одоо хүртэл БНХАУ-ын Шинэжаан уйгарын Өөртөө засах орны монголчуудын хэрэглэж байгаа тод үсэг нь үсэг зүй, авиа зүй, үг зүй, үгсийн сангийн талаар Жинхэнэ Шинэжааны Ойрадын аялгууг тусгасан тэдний тод үсэг болжээ.

Зая бандид монгол бичгийг тодорхой болгох зорилгоор тод үсэг зохиосон билээ. Энэ зорилгоо Зая бандид биелүүлжээ. Гэвч алив тодорхой бус бөгөөд нийтэд дэлгэрсэн үсгийг тодорхой болгох тутам тэрхүү бичгийн хэрэглэх хүрээ нь улам явцуу болдог ёсыг Зая бандид ойлгоогүй ажээ. Жишээлэхэд кирилл үсгийг аваад үзье. Кирилл үсэгт ө, ү нэмээд энэ үсгийг зөвхөн БНМАУ-ын хэмжээнд хэрэглэх болно. Кирилл үсэгт h(га)-г нэмж тодорхой болговол зөвхөн Зөвлөлт Халимагийн хэмжээнд л хэрэглэнэ. Мөн кирилл үсэгт (төвөнхийн шүргэх, сайн гэхэд hain гэж хэлэх жишээтэй) нэмж тодорхой болговол энэ үсэг зөвхөн Зөвлөлт Буриадад л хэрэглэгдэнэ.

II

УННС, Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөгт давхардсан тоогоор тод үсгийн 1000 ном цугларсан байна. Эдгээр номын нэг хэсэг буюу УННС-нд хадгалагдаж буй тод үсгийн номыг 1930-аад оны орчим цуглуулжээ. Тод үсгийн номын нөгөө хэсэг буюу Хэл зохиолын хүрээлэнгийн хөмрөгт хадгалагдан буй номыг 1965-1970 оны хооронд цуглуулсан байна. Дурдсан хоёр хөмрөгийн номыг нарийвчлан үзвэл бараг тал хувь нь (42,1 хувь) нь бурхан шашны холбогдолтой ном байна. Гэвч түүх уран зохиол, үсэг бичиг, сан тахилга, зурхай мэргэ төлгө, эм дом зэрэг цөөн боловч сонирхолтой номууд буй. «Сарны гэрэл» гэдэг намтарт Зая бандидын өөрийн орчуулсан 177 номын нэр буй. Бас гурван шавийн нэмж орчуулсан 37 номын нэр байдгийг бид сайн мэднэ.

Зая бандид барс жилээс барс жилийн хооронд буюу 1650-1662 оны хооронд орчуулсан номын нэрсийг «Сарны гэрэлд дурдсан байдгийг яг таг баримталж болохгүй юм. Учир нь зарим номын төгсгөлийн үгнээс үзвэл 1650 оноос өмнө буюу тод үсэг зохиохоос өмнө Зая бандид орчуулгынхаа ажлыг эхэлсэн ажээ. Жишээ нь «Банчин хутагтын тууж» гэдэг номыг 1642 онд Эцгийн номыг 1643 онд «Маань гамбу гамбум» гэдэг номыг 1643-1644 онд орчуулсан байна. Ингэхээр Зая бандидын орчуулга хийж эхэлсэн үе бол 1650 он бус 1642 он гэж үзэх бүрэн үндэстэй. Зая бандидын орчуулсан гэсэн төгсгөлийн үгтэй 65 ном Улаанбаатар хотын хоёр хөмрөгт 54, ЗХУ-ын Ленинград хотод 11 ном буй.

Зая бандидын орчуулсан номын төгсгөлийн үгэнд хаанахын хэн гэгч дурдсан, хэн гэгч хүн үнсэн самбарт бичсэн, хэн гэгч хүн түүнийг цаасанд буулгасан гэх зэргээр их тодорхой бичдэг заншилтай байжээ. Энэ бүхэн нь заримдаа түүхийн сонин баримт ч болох удаа бий. Ер нь Зая бандид төвд эхийг бариад самбарын бичээчид хэлж өгөхөд, тэр бичээч тэмдэглэн аваад дараа тэр самбарын бичээчийн бичсэн эхийг цаасанд буулган бичдэг баримтыг бид тодорхойлсон юм. Ингэснээр ч ахар хугацаанд олон номыг орчуулж амжсан байна. Энэхүү орчуулгын хэсэгт оролцож байсан зарим хүмүүс нь Зая бандидыг насан өөд болсоны дараа шавь нар бичээч зэрэг хүмүүс өөрсдөө бие даан ном орчуулах болсон юм. Эдгээрийн дотор Раднабадраа, Эрх цорж, Цүлтэмжамц, Ванжилжамц,

Шарав дайчин нанс, Даги, Төвд гэлэн Бандид цорж зэрэг долоон хүний орчуулсан ном бидэнд олдоод байна.

XVII зууны үеийн монгол даяарт бөө мөргөл зонхилж байв. Хязгаарлагдмал, орон нутгийн чанартай байсан бөө мөргөлтэй шаргуу тэмцэл хийж, Зая бандид «Зурхайн зуун үзэл», «гариг одны тохиол» зэрэг зурхайн ном, «Рашааны зүрхэн найман үет нууц увдисын үндэс» зэрэг анагаах ухааны холбогдолтой зохиол, «олон номын үндсэн үзгийн ялгал», «ёгт нэр, ёгт нэрийн тайлбар» зэрэг хэл бичгийн холбогдолтой зохиол, «мэдээтэй мэдээгүй ялгагч судар буюу үлгэрийн далай», «Эрдэнийн сан Сувашид» зэрэг уран зохиолын ном, «Найман мянган шүлэгт», «Билэг бармидын зэрэг» зэрэг гүн ухааны ном, «Таван сахъяа» буюу «Банзрагч», «Их тонилсоны зүгт дэлгэрүүлэгч» зэрэг бурхан шашны ном орчуулжээ. Зурхай, анагаах ухаан, хэл бичиг, уран зохиол гүн ухаан, бурхан шашны холбогдолтой өдий төдий олон зохиолыг монгол хэлэнд орчуулсан Ойрадын Зая бандидын үйл ажил бол тэр үедээ дэвшилттэй зүйл байв.

Үүгээрээ тэр үеийн Халх долоон хошуу ялангуяа Дөрвөн Ойрадыг орон нутгийн чанартай бөө мөргөлийн явцуу хүрээнээс татан гаргаж Энэтхэг, Төвдийн соёлын өргөн хүрээнд оруулсан учраас Зая бандидыг XVII зууны үеийн монгол дахины соёлын зүтгэлтэн гэж зохих ёсоор үнэлж байгаа юм.

ЭНЭТХЭГ, ТӨВД, МОНГОЛЫН УТГА ЗОХИОЛ, ТҮҮХ СОЁЛЫН ХАРИЛЦААНЫ УЛАМЖЛАЛ

Л. ХҮРЭЛБААТАР

Хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн

Монголын уран зохиолын дотор монгол зохиолчдын төвд хэлээр бичсэн олон зохиолыг оруулан судалбал зохино. Гэхдээ төвд хэлээр бичсэн тэдгээр зохиолыг зөвхөн Монголын тухайд салган авч үзэх биш, үүсч хөгжихөд нь нөлөө дууриал болсон Энэтхэг, Төвд зэрэг улс үндэстний зохиол бүтээлтэй холбон судлах хэрэгтэй юм. Ийнхүү судлах нь чухамдаа Энэтхэг, Төвд, Монголын утга зохиолын харьцаа, иргэний болон шашны агуулгатай зохиолын харьцааны асуудлыг ямар нэг талаар хөндөхөд хүргэнэ. Яагаад гэвэл утга зохиолын эл хэлхээ холбоо нь эрт дээр цагаас түүх соёлоор нягт зузаан харилцаатай явж ирсэн Энэтхэг, Төвд, Монголын харилцааны түүхээс үндэс сурвалжтай юм.

Юуны өмнө Энэтхэг, Монголын ном соёлын харилцаа нь өнө холын түүхтэй, эрх ба хожуугийн, дам ба шууд, олон замын харилцаа байсныг тэмдэглэвэл зохино. Энэ тухай академич Ц.Дамдинсүрэн бичихдээ: «Ганга мөрний хөндийгөөс цаст Гимлайн өндөр уулыг давж Монголын тал руу урссан соёлын олон мянган шижим байна»¹ гэжээ. Тэгвэл бид олон үеийн турш Монголд нэвтэрсэн Энэтхэг, Төвдийн гаралтай уран зохиолын баялаг уламжлалыг тэрхүү олон мянган алтан шижмийн» нэ-